

Монголын орчин үеийн уран зохиол дахь
нүүдэлчдийн үг хэллэгийн онцлогоос

Цэдэнпилийн ЦЭВЭЛМАА*

Монгол Улс, Шинжлэх ухаан, Технологийн Их Сургууль,
Гадаад хэлний сургууль

Received: 31 August 2025 / Accepted: 15 October 2025 / Published: 30 December 2025

Хураангуй: Монголчууд аман болон бичгийн соёлын асар их өв уламжлалтай ард түмэн билээ. Эдүгээ бидний үе хүртэл хөгжиж ирсэн бичгийн уран зохиолын мянга гаруй жилийн түүхэнд яруу найраг нь нийгэм, соёлын өөрчлөлт шинэчлэлтийг хамгийн түрүүн тусгаж ирсэн уламжлалтай. Нүүдлийн соёл иргэнийлт монголчуудын бусад улс үндэстнээс ялгарах ондоошил нь тэдний эрхэлж буй мал аж ахуй, байгаль экологийн унаган төрх байдал, өдөр тутмын ахуй амьдралтай нягт уялдаа холбоотой бөгөөд эдгээрийг илэрхийлсэн онцлог үг хэллэгтэй байдаг. Иймд энэхүү өгүүлэлдээ бид “Ардын уран зохиолч” Б.Лхагвасүрэнгийн уран бүтээл дэх нүүдэлчдийн үг хэллэгийн тухай, энэ нь хэлний дархлаанд хэрхэн нөлөөлөх тухай товч судлахыг хичээлээ.

Түлхүүр үгс: Орчин үеийн уран зохиол, “Ардын уран зохиолч”, соёл түүх, зан заншил, өвөрмөц онцлог

On the Characteristics of Nomadic Expressions
in Contemporary Mongolian Literature

TSEVELMAA Tsendenpil

School of Foreign Languages, Mongolian University of Science and Technology,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: The 1990s were a special period in the development of contemporary Mongolian prose poetry, for example, the literary movements in Mongolian poetry were from oral to written literature; from meditation to realism; from realism to postmodernism; from oriental tradition to Russian and European literature; and from classic nomadic culture to urban culture. Moreover, this period was a

* © Ц.Цэвэлмаа, 2025, Email: tsevelmaa.tsed@gmail.com



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

special time of literature reform when literary criticism was founded as a separate field to study prose poems. In this article, we aim to illustrate and analyze the unique imagery and cultural expressions found in the literary works of B. Lkhagvasuren, who holds the titles “People’s Writer”. For instance, in his poetic descriptions of the traditional Mongolian dwelling, the ger Lkhagvasuren employs symbolic methods that reflect the distinctive worldview of the Mongolian people. Through depictions rooted in the everyday life of nomads, he conveys fundamental aspects of Mongolian culture and customs. These include the structure of the ger, the domestic craftsmanship of Mongolian women, the sacred bond between mother and child, solar time, cardinal directions, and numerological symbolism.

Key words: Mongolian Modern Literature, Poetry, Customs, Innovation and Tradition

1. Удиртгал

Аливаа улс үндэстний бичиг соёлын түүхэн хөгжил нь тухайн үндэстнийхээ түүх, нийгэм, эдийн засаг, соёлын хөгжил дэвшилтэй салшгүй холбоотой байдаг. Монгол хэлний дархлаа гэдэг нь монгол хэлний оршин тогтнох, хөгжин бэхжих, хадгалагдах чадвар бөгөөд хэлний хэрэглээ, соёл, хууль эрх зүй, боловсрол, технологи, харилцан яриа зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг. Сүүлийн жилүүдэд монголчуудын дунд эх хэлний хэрэглээ сулрах болсон шалтгаан нь шинжлэх ухаан, техник технологийн өндөр хөгжил, улс хоорондын соёлын даяаршил, гадаад үгийг их хэрэглэх, хэл ярианы соёлгүй байдал, цахим орчны нөлөөгөөр дуудлагаараа бичих зэрэг юм. Үүний улмаас хэлний дархлаа буюу монгол хэлний үнэн зөв, цэвэр хэрэглээ, хэлний соёл, сэтгэлгээ, хандлагын тогтвортой байдал алдагдаж байна.

Аливаа улс үндэстэн, ард түмний өв уламжлал, түүх соёлын салшгүй нэгэн үнэт зүйл, оюун санааны тусгал болж, үндэстний өвөрмөц онцлог, зан заншлыг хөгжүүлэн, түүх соёлоо хойч үедээ өвлүүлэн үлдээх арга замын нэг нь уран зохиол (Бигэрмаа, 2016:25) юм. Уран зохиол нь хүний амьдралын хамгийн чухал урлаг юм. Учир нь улс үндэстэн бүр өөрийн төрөлх хэлээр гайхамшигт урлагийн бүтээлийг туурвиж, өөрийн болон бусад улс үндэстний түүх соёлыг мэддэг. Ямар ч улс үндэстэн бусад үндэстнээс ялгаатай хөгждөг, өөр өөр түүхэн замналтай байдаг. Үндэстэн бүр өөр өөр соёл, сэтгэлгээг бүтээхийн зэрэгцээ, байгальтай харьцах харьцаа, хандлага зэргээрээ ч ялгаатай байдаг.

Монголчууд бичгийн уран зохиолын мянга гаруй жилийн арвин туршлагатай ард түмэн бөгөөд Монголын орчин үеийн уран зохиол нь 1921 онд ардын хувьсгал ялж, “Шивээ хиагт” дууг зохиосноор эхэлдэг. Энэ үеэс хойш өмнөх үеийн дэвшилтэт өв, дэлхийн уран зохиолын сонгодог уламжлал дээр суурилан, улам боловсронгуй болж хөгжсөөр иржээ. Үе бүхэн өөрийн хэвшсэн хэв загвар, түүнийг манлайлан хошуучлагчтай байж, дараа дараагийн шилдэг зохиолчдын уламжлал болсоор иржээ.

Монголын уран зохиолын хөгжлийн түүхэнд өөрсдийн уран бүтээл, туурвилаараа бусдаас өвөрмөц ялгаатай, ур чадвар, сэтгэлгээний хувьд онцгой зохиолчдод “Ардын уран зохиолч” цол хүртээдэг бөгөөд эхний шагналыг Төрийн 3 удаагийн шагналт, зохиолч, академич Ц.Дамдинсүрэн хүртсэн билээ. Түүнээс хойш олон зохиолчид тус шагналыг хүртээд байна. “Ардын уран зохиолч”-ийн уран бүтээл нь тэдгээрийн эрдэм авьяас, оюуны соёл, сэтгэлгээний цар хүрээ, сэтгэх ба илэрхийлэх онцлог, гүн ухааны үзэл баримтлал, сэтгэлийн дотоод ертөнцийг бүхэлд нь багтаасан баялаг агуулгатай бөгөөд амьдрал, аж төрөхүйн учир ёсон хийгээд хөг аялгуун, утга соёл, урлагийн өвөрмөц төгс төгөлдөр уран бүтээлийг туурвихдаа зохиолч бүр өөрийн гэсэн өвөрмөц онцлог, арга барилаар илэрхийлсэн байдаг.

Энэхүү өгүүлэлдээ бид “Ардын уран зохиолч”, “Хөдөлмөрийн баатар” Б.Лхагвасүрэнгийн уран бүтээлээс сонгон авч, монгол соёлын онцлогийг илэрхийлсэн, өвөрмөц дүрслэлүүдийг жишээгээр батлан тайлбарлахдаа үг хэллэгийг ялган ажиглаж, үндэсний онцлогт үг хэллэгийг тодруулахын зэрэгцээ тус үг хэллэг нь монгол хэлний дархлаанд хэрхэн нөлөөлөх талаар судлахыг хичээлээ. Тухайлбал, монголчуудын үндэсний сууц болох монгол гэрийн тухай өгүүлэмжийг Б.Лхагвасүрэн өөрийн уран бүтээлд монголчуудын сэтгэлгээний онцлог болох

бэлгэдэл зүйн аргыг ашиглан дүрслэхдээ тэдний ахуй амьдралын зураглалд тулгуурлан, монгол соёл зан заншлын үндсэн онцлог, гэрийн бүтэц, монгол эмэгтэйн үйл мэтгэх урлаг, эх үрийн нандин холбоо, наран цаг, зүг чиг, тооны бэлгэдэл зэргээр дүрслэн өгүүлсэн бөгөөд ингэхдээ өдөр тутмын ахуй амьдралаас үүдэн, үндэсний онцлогтой үг хэллэгийг хэрэглэн дүрсэлсэн байдаг. Өөрөөр хэлбэл, бусад улс үндэстний ард түмний ойлгохгүй, зөвхөн монголчуудын ойлгох үг хэллэгийг хэрэглэн дүрсэлсэн нь онцлог юм.

2. Судалгааны арга зүй

Энэхүү өгүүлэлдээ уран зохиолын онолын суурь судалгааны бүтээлүүд, “Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэн”-гийн түүвэр зохиол, судалгаа шинжилгээний арга зүйн бүтээлүүдийг хэрэглэгдэхүүн болгохын зэрэгцээ задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх болон ажиглалтын аргыг хэрэглэсэн болно.

3. Б.Лхагвасүрэнгийн уран бүтээл дэх соёл сэтгэлгээний онцлог

Зохиолчийн найруулга нь бүтээн туурвих үйл явц, сэтгэлгээний хэв маяг, эрэл хайгуулын үр дүнд зохиолч бүрд өвөрмөц байдлаар төлөвшдөг бөгөөд бичлэг, сэтгэлгээ, ур чадвар, туршлагын талаар бусдаас ялгарах онцлог шинж юм. Өөрөөр хэлбэл, зохиолчийн бүтээн туурвих үйл явцад зохиолоор дамжин илэрхийлэгдэж байдаг өгүүлэгдэхүүн, дүрслэх хэв маяг, хэлийг ашигласан байдал зэрэг юм. Иймд зохиолч бүр бусад зохиолчоос ялгарах, туурвин бүтээх найруулгын өвөрмөц онцлогтой билээ.

Зохиолч хүний гол эрдэм, бусдаас ялгарах гол үзүүлэлт нь хэлийг эзэмдэн эрхшээх, үг хэлийг өөрийн уран сайхны зорилгод ашиглах онцгой чадвар, найруулах эрдэмтэй холбоотой. Иймээс уран зохиол судлалд зохиолчийн хэл, ур чадвар, найруулах эрдмийн асуудал онцгой байртай байдаг. Ер нь зохиолчийн ур чадвар, уран дүрслэлийн онцлогийг тодруулах чухал онцлог нь үгийн санг зохиолдоо хэрхэн хэрэглэснээс хамаардаг. Энэхүү өгүүлэлдээ бид 1980-1990-ээд оны Монголын орчин үеийн яруу найрагт шинэчлэл хийсэн хэмээн судлаач, шүүмжлэгчдийн хүлээн зөвшөөрдөг, нэрт яруу найрагч Б.Лхагвасүрэнгийн яруу найраг дахь туршлагыг авч үзнэ. Түүний яруу найрагт жиших, адилтгах, үг, өгүүлбэр, шад, бадаг давтах, эн зэрэгцүүлэл, лавшруулал, бэлгэдэл, харшуулал, сөргүүлэл, ёгтлол, егөөдөл, уран асуулга, анхааруулга зэрэг олон зүйл найруулгын хэв маягийг дангаар болон зохистой нийлэгшүүлэн хэрэглэсэн нь тухайн үеийн бусад яруу найрагчдаас ялгарах бас нэгэн онцгой чадвар байдаг. Тухайлбал: Монгол ёс заншил, соёл, түүхийг эгэл амьдрал, жирийн явдлаас ургуулан, уран санаагаар баяжуулж, хүний сэтгэлийн хөг аястай нарийн холбон, мэдрэмжтэй шүлэглэдэг бөгөөд ийм өвөрмөц найруулга, уран зохиомж бүхий олон шүлэг байдаг. Тухайлбал: “Тэдний нүүдэл миний зүрхэн дээрээс хөдөлнө” шүлэгтээ монгол соёл, малчин айлын амьдралын болон нүүдлийн хэв маяг, зан заншил, айл саахалт амьдардаг монгол хүүхдүүдийн хамт тоглож өссөн бага насны дурсамж зэргийг монгол хүүхдийн сэтгэлгээгээр дүрсэлсэн нь онцлог юм. Шүлгийн үндсэн агуулгыг Сайртын хаваржаанд айлсдаг айлуудын хүүхдүүдийн бага насны дурсамж маягаар өгүүлсэн бөгөөд мал аж ахуй эрхэлдэг монголчуудын бага насны хүүхдүүд байгаль орчинтойгоо нягт уялдаа холбоотойгоор нүүдэллэн амьдрахдаа айл гэр болж тоглох, шивээ ганхах, хадны цуурай, харганын оройд шаазгай шагшрах, толгодоор дэгдэх зэрэглээ, хорол зурж дэрс хатган наран цаг хийх, хоёр шивээ барилдуулан, наадам үзэх, эвтэй байхад хонь сайхан тогтох, их үдийн саам болоход эжий нь цэнхэр алчуураар даллах зэрэгт багтаан өгүүлсэн байдаг. Шүлгийн төгсгөл хэсэгт “Би” баатрын сэтгэлийн хөдөлгөөнийг дүрслэхдээ:

“...Ат орилон, унь шаргиж Пунсаагийнх ачаална

Алаг нүдэн Пунсаа гарыг минь байн байн атгана.

Тэдний нүүдэл миний зүрхэн дээрээс хөдөлнө

Тэнхэн тэнхэн алхуулсаар шар униранд живнэ

Чамаас харамладаг байсан чулуун олон сүргээсээ

Чөдрийн ганц морь ч үлдээлгүй өгдөг байж гэж бодоход

Самсаа бохирон, нүдэнд манан бударч

Саахалтын шар толгод нулимсанд нурна
Туульс шиг урт, намар өвлийн зургаан сард
Пунсааг би санана
Туж л Сайртын хаваржаанд

Пунсаатай тоглож зүүдэлнэ (Лхагвасүрэн, 2006:54) хэмээн, монгол нүүдлийн зан заншлаас эхлээд, өвөлжөөнд салж нүүдэллэж буй амьдралын хэв маягийг өгүүлж, эдгээрийг дүрслэхдээ тухайн агшныг өгүүлсэн, нүүдэлчдийн үг хэллэгийг ашигласан байна.

Тухайлбал, энэхүү шүлгээс монгол ахуйг илэрхийлсэн зарим дүрслэлүүдийг түүж үзье. Жишээлбэл:

Сайртын хаваржаанд айлстлаа...

Пунсааг би санадаг ч

Туж л сайртын хаваржаанд

Пунсаатай тоглож зүүдэлнэ... (Лхагвасүрэн, 2006:53)

Байгалийн эрс тэс уур амьсгалтай, жилийн дөрвөн улиралд нүүдэллэн амьдардаг монголчууд мал ахуйдаа тохируулан, улирал улирлаар өөр газарт очиж нутагладаг. Энэ нь тухайн улирлын онцлогоос шалтгаалдаг бөгөөд энэхүү нүүдэллэн амьдарч буй газраа “Хаваржаа, намаржаа...” гэх мэтээр улирлын нэрээр нэрлэнэ. Шүлэгт жил бүр хаваржаандаа айлсан буудаг, айлуудын хүүхдийн амьдралыг дүрсэлжээ. Монгол хүүхдүүд өөрсдөө мал адгуулан явах зуур хамгийн элбэг байдаг байгалийн төрөл бүрийн хэлбэр дүрс, өнгө бүхий чулуугаар монгол гэр, түүний орчныг бий болгон өрж тоглодог нь бусад улс үндэстнээс ялгарах үндэсний өвөрмөц соёлын нэг юм. Тэд чулуугаар барьсан гэртээ янз бүрийн эд хогшлыг мөн л чулуугаар орлуулан тоглодог бөгөөд энэхүү чулуун тоглоом нь байгаль дэлхийтэйгээ ойр байж, монгол ахуйгаа танин мэдэх, хөгжүүлэх, байгалиа хайрлан үзлийг төлөвшүүлдэг байсан нь

“Айл болж тоглосон чулуун гэрийн дотор...” (Лхагвасүрэн, 2006:53) гэсэн үг шадаас харахад тодорхой байна.

Зөвхөн үүгээр зогсохгүй, монголчуудын уламжлалт цаг хугацааны хэмжүүр наран цагийг **“Хорол зурж дэрс хатган нар баримжаалж...”** (Лхагвасүрэн, 2006:53) хэмээн илэрхийлж, хонио хотлуулах цагаа баримжаалдаг байсныг дүрсэлсэн байна. Мэндлэх хүндлэх ёсыг монголчуудын харилцааны соёлын цагаан толгой гэж нэрлэдэг, хооронд нь салгаж болохгүй чухал ойлголтын нэг юм. Монголчууд эрт дээр үеэс аян замд гарах гэж буй хүмүүст зориулан, **“Алтан шар зам нь цагаан байх болтугай!”** хэмээн ерөөж, малынхаа цэвэр ариун сүүгээр замыг нь мялаадаг бөгөөд сүүгээ өргөхдөө цацлын халбага хэмээх жижигхэн модон халбага ашигладаг амьдралын туршлагыг, хүүхдийн сэтгэлд буй өхөөрдөм хөөрхөн гартай нь **“Цацлын халбага шиг гараараа даллан...”** гэсэн нь онцлог болжээ. (Лхагвасүрэн, 2006:53)

Монголчууд нүүдлийн мал аж ахуйг эрхэлж, ахуй амьдралаа авч явахдаа байгаль, цаг агаар, орчин нөхцөлтэйгөө хамгийн ойрхон байдаг бөгөөд байгалийн байдлыг ажиглан, амьдралынхаа туршлагаар цаг агаарыг шинжлэх, нараар баримжаалан цаг тогтоох зэрэг сонирхолтой, өвөрмөц туршлагатай ард түмэн юм. Тэд цагийн баримжаа авахдаа нарийн саваа модыг газарт хатгаж, сүүдэр нь эгц тусаж байвал, жин үд болж байна хэмээн наран цагийг ашигладаг байсан байна. (Бигэрмаа, 2024:5)

Хорол гэдэг нь дугариг 12 хэсэгтэй, 12 хэсэг бүр нь 12 жилийн амьтнаар төлөөлүүлдэг дүрсэлдэг ажээ. Энэхүү уламжлал соёлын онцлогийг **“Хорол зурж дэрс хатган нар баримжаалж...”** (Лхагвасүрэн, 2006:53) хэмээн илэрхийлсэн нь бусад улс үндэстэнд давтагдахгүй, нүүдэлчдийн соёлыг илэрхийлсэн дүрслэл болжээ. Шоглож зүтгүйтсэнийхээ дараа **“Хадны цуурай аавд нь ховлох вий”, “Харганын орой дахь шаазгай ээжид нь хэлэх вий”** гэж буй нь үндэсний онцлогийг харуулсан бэлгэдэл зүйн бас нэгэн жишээ болсон байна.

Хоёр шивээ барилдуулан “Наадам” үзэж... (Лхагвасүрэн, 2006:53) гэсэн үг хэллэгт Чингис хааны үеэс уламжлан ирсэн “Эрийн гурван наадам”-ын нэг бөхийн барилдааныг монгол хүүхдүүд хэрхэн наадам тоглоомдоо хэрэглэж буйг дүрсэлжээ. (Энэ нь 2 шивээгээ бөх болгон, дундуур нь нугалж, хооронд нь гогцоолдож 2 тийшээ татаж тоглодог тоглоом бөгөөд эхэлж тасарсан нь унаж байгаа гэсэн үг.)

Мөн *Их үдийн саам болж...*

Намхан уулсынхаа бэлд “Асгасан сувдаа” хумьсаар... гэсэн үг хэллэгээр хонийг монголчуудын есөн эрдэнийн нэг болох үнэт зүйл сувдтай зүйрлэсэн нь цагаан өнгөөр үнэтэй эрдэнэ юм гэж, өөрөөр хэлбэл, монголчуудын хувьд мал нь юутай ч зүйрлэшгүй үнэт эрдэнэ буюу өөрсдийнх нь нэрлэдгээр “Амьд таван эрдэнэ”-ийн нэг юм гэдгийг харуулжээ.

Нарны тоос босгон хонио бид хотлуулна... (Лхагвасүрэн, 2006:53) хэмээн дүрсэлсэн нь нараар цаг баримжаалж, наран цагийг ашиглан, амьдралынхаа хэв маягийг сахиж ирсэн монголчууд мал сүргээ асгасан сувдтай зүйрлэн, магтахын зэрэгцээ зуны дэлгэр цагт (хонины саам) унага барьж гүүнээс саам авч, айраг цагаа эсгэн зусаж, ундаа болгон хэрэглэдэг. Ингэхдээ өдрийн 8 удаагийн саам авдаг, энэ цаг нь мэдээж хоорондоо нарийн тогтсон байдаг.

Тэрчлэн *Ат орилж, унь шаргиж Пунсаагийнх ачаална...*

...Тэдний нүүдэл миний зүрхэн дээрээс хөдөлнө... сэтгэлгээний онцлог

Чамаас харамладаг байсан чулуун олон сүргээсээ...

Чөдрийн ганц морь ч үлдээлгүй өгдөг байж гэж бодоход... (Лхагвасүрэн, 2006:53)

Саахалтын шар толгод нулимсанд нурна... (Лхагвасүрэн, 2006:53) гэх мэтээр зөвхөн монголчуудын ойлгож чадах сэтгэлгээний онцлогийг тусгасан, өвөрмөц сонирхолтой дүрслэлүүдийг харуулжээ. Ер нь монгол хүүхдүүдийн гол тоглодог эд хэрэгсэл чулуу байсан бөгөөд энэ нь тэдний үндсэн тоглоом юм. Чулуун тоглоомоор тоглох нь байгаль орчноо танин мэдэх, амьдралын туршлагатай болох, мөн үнэгүй, бат бөх чанарыг агуулсан, тоглох явцдаа хүн, байгалийн хооронд хэрхэн яаж нөлөөлдгийг сайн мэддэг болдог. Энэ мэтчлэн шүлгийг бүхэлд нь уншиж үзэхэд, зөвхөн монгол нүүдлийн соёл иргэншлийн онцлогийг дүрсэлсэн дүрслэлүүд, монголчуудын өвөрмөц сэтгэлгээг харж болно.

4. Судалгааны үр дүн

Дээрх судалгаанаас харахад, монголчуудын үндэсний түүх соёл, зан заншил, ахуй амьдрал, өв соёл нь үндэсний онцлогтой үг хэллэгээр дамжин, хойч үедээ өвлөгдөн үлддэг бөгөөд үүний нэг арга зам бол уран зохиол, түүний дотроос яруу найргийн төрлөөр уламжлагдан үлдэх явдал юм. Ер нь ямар ч хэлний үгийн сангийн ихэнх хувийг үндэсний онцлогтой үг хэллэг эзэлдэг. Монголчуудын үндэсний онцлог үг хэллэгийг ажиглахад, монгол үндэстний уламжлалт амьдрал, зан заншил, эрхэлдэг аж ахуйн олон талт үйл ажиллагаа, нийгэм улс төр, шашин, соёлын болон газар нутаг, амьтан, ургамлын онцлогийг тусгасан утга бүхий үг хэллэг байгаа нь харагдаж байна.

Монгол хэлний үндэсний онцлог бүхий үг хэллэг нь бидний соёл сэтгэлгээ, зан заншил, уламжлалыг хадгалсан язгуур үнэт зүйлсийн нэг юм. Нүүдлийн соёл иргэншилтэй монголын ард түмэн үр хүүхдээ үгийн гайхамшигт ид шидээр хүмүүжүүлэн "Хүнээр хүн хийдэг" байсны онцлог нь ингэж монголын орчин үеийн яруу найрагт үндэсний онцлогтой үг хэллэгээр дүрсэлж байгаагаар бүрэн дүүрэн тусгалаа олжээ

Нөгөө талаас аливаа үндэстний оршин тогтнох хамгийн гол хүчин зүйл нь хэл юм. Харин хэлний дархлааг тогтвортой хадгалдаг нэг чухал хүчин зүйл нь бичгийн хэл ажээ Бичгийн хэлгүй, зөвхөн аман ярианы хэлтэй бол тухайн улсын хэл мөхөх аюул ойрхон байдаг байна. Эдүгээ дэлхий нийтийн даяаршлын түрлэгт өртөж, технологийн эрин зуунд алхам алхмаар уусаж буй энэ цаг үед хэлний дархлаа нь үндэстэн бүрийн өөрийгөө хамгаалах, хадгалах, шинэчлэх чадвар юм.

Орчин үед гадаад хэлний давамгайлал, цахим орчин дахь англи хэлний хэт хэрэглээ, боловсролын систем дэх хэлний бодлогын сул байдал, залуу үеийн хэл ярианы соёлд үүсэж буй гажуудал зэрэг нь эх хэлний дархлааг бууруулах шалтгаан болж байна.

5. Дүгнэлт

Дээрх зүйлүүдээс дүгнэхэд:

1. Нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг, өвөрмөц соёл, түүхтэй монголчуудын сэтгэлгээ нь эрхэлж буй мал аж ахуй, идээшиж буй байгаль орчинтойгоо нягт уялдаатай гэдгийг үндэсний онцлог бүхий үг хэллэгээр сонирхолтойгоор дүрслэн харуулжээ.
2. Нүүдлийн соёл иргэншлийн салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг нь жилийн дөрвөн улиралд тохируулан нүүдэллэх соёл бөгөөд энэхүү зан заншлыг монгол хүүхдийн хоорондын харьцаагаар дүрсэлсэн нь монголын орчин үеийн уран зохиолд шинэлэг зүйл болсон нь харагдаж байна.
3. Монгол хүмүүс бага наснаасаа эхлэн, байгаль дэлхийтэйгээ харьцаж, өөрийн амьдралын туршлагыг бий болгон, хүмүүждэг онцлогтой ард түмэн юм. Иймд шинжлэх ухаан, техник технологийн үсрэнгүй хөгжилтэй уялдан, нүүдлийн соёл иргэншлээс суурин соёл иргэншил рүү шилжиж байгаа өнөөгийн нийгэмд монголчууд бид өвөрмөц соёл, зан заншлаа мөхөөхгүй авч явах нь бидний өмнө тавигдаж буй чухал шаардлагын нэг болжээ.
4. Шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй хөгжил бүхий өнөөгийн нийгэмд улс үндэстний хэлний дархлааг хамгаалах арга замын нэг уран зохиол, ялангуяа яруу найраг дахь үндэсний онцлог бүхий үг хэллэгээр дамжуулан, хойч үедээ өвлүүлэн үлдээх явдал юм.

Ном зүй

- Бигэрмаа, Р.** (2016). *XX зууны яруу найргийн шинэтгэл шинж*. Улаанбаатар. [Bigermaa, R. *XX зууны mongol yaruu nairgiin shinetgel shinj* [The Literary Movements in the Twentieth Century Prose Poetry Mongolian Ulaanbaatar:2016]
- Галбаатар, Д.** (2012). *Уран зохиолын нэвтэрхий толь: Онол, түүх, шүүмжлэл*. Улаанбаатар.Соёмбо ХХК [Galbaatar, D *Uran zokhiolyn nevertkhii toli:Onol, tuukh, shuumjlel* [Encyclopedia of Literatre: Theory, History and Critism.] Ulaanbaatar. Soyombo Print LLC 2012]
- Дулам, С.** (2007). *Монгол бэлгэдэл зүй*. Улаанбаатар. Бит Пресс ХХК. [Dulam S. [Mongol belgedel zuii. [Mongolian Symbolism I: Symbolism of Numbers]. Ulaanbaatar. Bit Press LLC]
- Дулам, С.** (2007). *Монгол бэлгэдэл зүй*. Улаанбаатар. Бит Пресс ХХК. Dulam S. [Mongol belgedel zuii. [Mongolian Symbolism II: Symbolism of Direction". Ulaanbaatar. Bit Press LLC 2007]
- Лхагвасүрэн, Б.**(2006). *Бүрэн түүвэр. Тэргүүн дэвтэр*. Бээжин [Lkhagvasuren, B. *Büren tüüver:Tergüin devter.*] [Collected works, First volume] Beejin.2006.]